



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 8/42

Чингис хот

**Дамсрангүнгийн Мягмарбаатарыг  
хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 23.2, 23.2.2, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулийн 3.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомжийн мэдээлэл, системчлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд ажлын зайлшгүй шаардлагаар Дамсрангүнгийн Мягмарбаатарыг 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм цуцлагдах хүртэлх хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажилласугай.

2. Д.Мягмарбаатарын цалинг ТЗ-5-1 шатлалтай адилтган тогтоож, үндсэн цалинг 642,388 (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Мягмарбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР